



САНГИЙН ЯАМ

МОНГОЛ УЛСЫН ХАГАС ЖИЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, ТӨСВИЙН ТОЙМ



2024

АГУУЛГА

ХУРААНГУЙ ДҮГНЭЛТ	5
БҮЛЭГ НЭГ. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ХАГАС ЖИЛИЙН ТОЙМ	7
1.1. МОНГОЛ УЛСЫН ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН, ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ 7	
1.1.1. Үйлдвэрлэлийн аргаар тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүн.....	7
1.1.2. Эцсийн ашиглалтын аргаар тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүн	8
1.2. ГАДААД ХУДАЛДАА	10
1.3. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ.....	12
1.4. ИНФЛЯЦ	12
БҮЛЭГ ХОЁР. 2024 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛ	15
2.1. ТӨСВИЙН ОРЛОГО	15
2.1.1. Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэл.....	15
2.1.2. Уул уурхайн салбарын орлогын гүйцэтгэл.....	16
2.2. ТӨСВИЙН ЗАРЛАГА	17
2.3. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	18
2.4. ЗАСГИЙН ГАЗРЫН ГАДААД ЗЭЭЛ, ТУСЛАМЖ.....	20
2.5. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСӨВ	21
2.6. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР	22
2.7. ЗАСГИЙН ГАЗРЫН ДОТООД ҮНЭТ ЦААС	24
2.8. ЗАСГИЙН ГАЗРЫН ГАДААД ЗЭЭЛ	24
2.9. ЗАСГИЙН ГАЗРЫН ГАДААД ҮНЭТ ЦААС	24
2.10. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН БАТАЛГАА.....	25
БҮЛЭГ ГУРАВ. МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСАГ, ТӨСВИЙН ХҮЛЭЭГДЭЖ БҮЙ ГҮЙЦЭТГЭЛ	27
3.1. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ	27
3.2. ГАДААД ХУДАЛДАА	28
3.3. ИНФЛЯЦ	28
3.4. ТӨСВИЙН ОРЛОГЫН ХҮЛЭЭГДЭЖ БҮЙ ГҮЙЦЭТГЭЛ.....	28
3.5. ТӨСВИЙН УРСГАЛ ЗАРЛАГЫН ХҮЛЭЭГДЭЖ БҮЙ ГҮЙЦЭТГЭЛ.....	28
БҮЛЭГ ДӨРӨВ. МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСАГТ УЧИРЧ БОЛЗОШГУЙ ЭРСДЭЛҮҮД	30
4.1. ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТОДОРХОЙ БУС БАЙДАЛ	30

4.1.1	Түүхий эдийн эрэлт, үнэ буурах.....	30
4.1.2	Дэлхийн эдийн засгийн сэргэлт удаашрах	31
4.2.	ДОТООДОД ҮҮСЭЖ БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛ.....	31
4.2.1.	Малын өвчин, цаг агаар, ган зудын эрсдэл	31
4.2.2.	Зээлжих зэрэглэл буурах болон аливаа төрлийн хориг	31

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

ГРАФИК 1. ДНБ-ий өсөлтийн бүтэц, улирлаар (хувь)	7
ГРАФИК 2. Малын хорогдол, төрлөөр, мян.толгой	8
ГРАФИК 3. Малын хорогдол, аймгаар, мян.толгой	8
ГРАФИК 4. Өрхийн сарын дундаж орлого, мянган төгрөг	10
ГРАФИК 5. Өрхийн бодит орлого бүрэлдэхүүнээр, мянган төгрөг	10
ГРАФИК 6. Гадаад худалдааны нийт бараа эргэлт (тэрбум ам.доллар)	10
ГРАФИК 7. Нийт нүүрсний олборлолт ба экспорт, сая.тонн	11
ГРАФИК 8. Төлбөрийн тэнцэл (сая ам.доллар)	12
ГРАФИК 9. Жилийн инфляц ба зорилтот түвшин (хувь)	13
ГРАФИК 10. Засгийн газрын дотоод үнэт цаас (их наяд төгрөг)	24

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Эдийн засгийн өсөлт эхний хагас жилээр, салбаруудын хувь нэмэр (хувь) 7	
Хүснэгт 2. Эцсийн ашиглалтын аргаар тооцсон бодит ДНБ-ий өсөлт, бүрэлдэхүүнээр (хувь)	9
Хүснэгт 3. Чулуун нүүрсний экспорт, боомтоор, сая.тонн	11
Хүснэгт 4. 2024 оны эхний 6 сарын нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэл (тэрбум төгрөг)	16
Хүснэгт 5. 2024 оны эхний 6 сарын уул уурхайн салбарын орлогын гүйцэтгэл, ашигт малтмалын төрлөөр (тэрбум төгрөг)	16
Хүснэгт 6. 2024 оны эхний 6 сарын төсвийн зарлагын гүйцэтгэл (тэрбум төгрөг)	17
Хүснэгт 7. Улсын төсвийн хөрөнгө оруулалт (тэрбум төгрөг)	18
Хүснэгт 8. Засгийн газрын гадаад зээл, тусламжийн гүйцэтгэл (тэрбум төгрөг)	20
Хүснэгт 9. Гадаад зээл, тусламжийн төсөл хөтөлбөр, хөгжлийн түншээр (тэрбум төгрөг)	20
Хүснэгт 10. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага (тэрбум төгрөг)	21
Хүснэгт 11. Засгийн газрын өрийн бүтэц (тэрбум төгрөг)	23
Хүснэгт 12. Засгийн газрын дотоод үнэт цаас (их наяд төгрөг)	24
Хүснэгт 13. Засгийн газрын өрийн баталгааны үлдэгдэл (тэрбум төгрөг)	25
Хүснэгт 14. Макро эдийн засаг болон улсын төсвийн үзүүлэлтүүд	27
Хүснэгт 15. БНХАУ-ын эдийн засгийн өсөлт ба голлох түүхий эдийн үнийн төсөөлөл	30

ШИГТГЭЭНИЙ ЖАГСААЛТ

Шигтгээ 1. Том малын зүй бус хорогдол	8
Шигтгээ 2. Өрхийн бодит орлого	10
Шигтгээ 3. Нүүрсний олборлолт, экспорт	11
Шигтгээ 4. 2024 оны төсвийн бодлогын тойм	15

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ААНОАТ	Аж ахуй нэгжийн орлогын албан татвар
АДБХОБ	Азийн Дэд Бүтцийн Хөрөнгө Оруулалтын Банк
АХБ	Азийн Хөгжлийн банк
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНФУ	Бүгд Найрамдах Франц Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БНЭУ	Бүгд Найрамдах Энэтхэг Улс
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЕСБХБ	Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк
ЕХОБ	Европын Хөрөнгө Оруулалтын Банк
ЗГҮЦ	Засгийн газрын үнэт цаас
МИК	Монголын ипотекийн корпорац
МУХБ	Монгол Улсын Хөгжлийн Банк
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОУВС	Олон Улсын Валютын сан
ОХУ	Оросын Холбооны Улс
ТТС	Төсвийн тогтворжуулалтын сан
ТХХТ	Төр хувийн хэвшлийн түншлэл
УИХ	Улсын Их Хурал
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар

ХУРААНГУЙ ДҮГНЭЛТ

Сангийн яамны санаачилгаар 2021 оноос эхлэн Монгол улсын эдийн засаг, төсөв, хөрөнгө оруулалт, гадаадын зээл тусламжийн мэдээллийг иргэдэд ил тод, нээлттэй, ойлгомжтой байдлаар хүргэх үүднээс “Хагас жилийн эдийн засаг, төсвийн тойм”-ыг жил бүр бэлтгэн хүргэж байна. Тус эмхэтгэл нь иргэдэд төсөв, макро эдийн засгийн гүйцэтгэлд дүн шинжилгээ хийх, тус жилд хэрэгжих төсвийн бодлогын эдийн засаг, нийгэмд үзүүлэх нөлөөллийг таниулахад өндөр ач холбогдолтой юм.

Монгол улсын Засгийн газар 2024 оныг “Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил” болгон зарлаж, “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ыг шинэчлэн батлуулж, бүс бүр өөрийн онцлог, давуу талд суурилан хөгжих аж үйлдвэрлэл, хөрөнгө оруулалт, татвар, орон сууцжуулалт, бизнесийн орчныг сайжруулах төсвийн бодлогын арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Тухайлбал, Засгийн газраас төвлөрлийг сааруулж, орон нутаг дахь орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор ипотекийн 3 хувийн хөнгөлөлттэй зээлийг олгож байгаа бөгөөд 2024 оны 8 сарын байдлаар нийт 3,615 зээлдэгчид хамрагдсан байна.

Түүнчлэн, иргэдийн бодит орлогыг хамгаалах чиглэлд цалин, тэтгэвэр тэтгэмжийг инфляцын өсөлттэй уялдуулан нэмэгдүүлэх хүрээнд 2024 оны 4 сарын 1-ний өдрөөс эхлэн нийтлэг төрийн үйлчилгээ, хот тохижилт үйлчилгээний салбарын ажиллагсдын үндсэн цалинг 20 хувиар, бусад төрийн албан хаагчдын цалинг 10 хувиар, орон нутгийн нэмэгдлийг аймгийн төв болон хөдөөгийн сумаас хамааран сар бүр 20-40 хувь болгож тус тус нэмэгдүүлсэн. Мөн нийгмийн даатгалын сангаас олгох өндөр настны тэтгэврийн хэмжээг 100 мянган төгрөгөөр нэмэгдүүлж дундаж тэтгэврийн хэмжээг 785.6 мянгад хүргэлээ.

Экспортын сэргэлт үргэлжилж, хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, уул уурхайн бүтээгдэхүүний биржийн ил тод арилжааг эрчимжүүлсний нөлөөгөөр Монгол Улсын нийт экспорт 2024 оны эхний хагас жилд 7.9 тэрбум ам.долларт хүрч, гадаад валютын албан нөөц 4.8 тэрбум ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 1 тэрбум ам.доллараар нэмэгдлээ.

Монгол улсын эдийн засаг 2024 оны эхний хагас жилийн байдлаар 5.6 хувиар өсөж, инфляц 5.1 хувьд хүрч буурч, ажилгүйдлийн түвшин 5.8 хувьтай гарлаа. Макро эдийн засгийн эерэг үзүүлэлтийн үр дүнд үнийн нөлөөг арилгасан өрхийн бодит орлого өмнөх оны мөн үеэс 255 мянган төгрөгөөр буюу 17.3 хувиар өсөж, 1.7 сая төгрөгт хүрсэн байна.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.

МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ХАГАС ЖИЛИЙН
ТОЙМ

БҮЛЭГ НЭГ. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ХАГАС ЖИЛИЙН ТОЙМ

1.1. МОНГОЛ УЛСЫН ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН, ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ

1.1.1. Үйлдвэрлэлийн аргаар тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүн

Нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүн 2024 оны эхний хагас жилд 37.4 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 20.8 хувиар, 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон бодит ДНБ 14.4 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 5.6 хувиар тус тус өслөө. Эдийн засгийн өсөлтөд хөдөө аж ахуйгаас бусад салбарууд эерэг хувь нэмэр орууллаа.


Хүснэгт 1. Эдийн засгийн өсөлт эхний хагас жилээр, салбаруудын хувь нэмэр (хувь)

Үзүүлэлт	2021. II	2022. II	2023. II	2024. II
ДНБ	6.3	2.0	6.7	5.6
ХАА	-0.8	1.8	-1.7	-3.9
Уул уурхай	2.6	-4.0	3.9	1.8
Аж үйлдвэрлэл, барилга	0.1	-0.2	0.3	0.8
Боловсруулах	0.7	-0.2	0.1	0.4
Цахилгаан, ус	0.3	0.2	0.1	0.2
Барилга	-0.9	-0.2	0.1	0.3
Үйлчилгээ	1.4	2.6	3.8	4.4
Худалдаа	0.5	1.4	0.8	0.8
Тээвэр	0.3	-0.6	1.9	1.0
Бусад	0.6	1.8	1.1	2.6
Цэвэр татвар	3.0	1.7	0.4	2.3

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Уул уурхайн салбар 2024 оны эхний хагас жилд өмнөх оны мөн үеэс 15.4 хувиар тэлж, эдийн засгийн өсөлтийн 1.8 нэгж хувийг бүрдүүллээ. Үүнд нүүрс олборлолт 47.6 сая тоннд хүрч өмнөх оны мөн үеэс 35.9 хувиар, төмрийн хүдэр олборлолт 4.6 сая тоннд хүрч 47.2 хувиар тус тус өссөн нь голчлон нөлөөлөв. Харин зэсийн

График 1. ДНБ-ий өсөлтийн бүтэц, улирлаар (хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

баяжмалын үйлдвэрлэл өмнөх оны мөн үеийн түвшинтэй ойролцоо байгаа бол алт болон газрын тос олборлолт харгалзан 17.7 болон 13.5 хувиар тус тус буурсан байна. Түүнчлэн, уул уурхайн бүтээгдэхүүний экспортын тээвэр болон бараа, бүтээгдэхүүний импорт өссөнөөр ачаа тээвэр 2024 оны эхний улиралд 55.6 сая тоннд хүрч, тээврийн салбарын үйлдвэрлэл 24.7 хувиар тэлэв.

Инженерийн дэд бүтцийн томоохон бүтээн байгуулалтуудын нөлөөгөөр барилгын салбар эхний хагас жилд 19.5 хувиар өссөн бол хүнсний зарим бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдсэнээр боловсруулах салбар 6.3 хувиар тэллээ.

Энэ оны эхний хагас жилд дотоодын эдийн засгийн идэвхжил, өрхийн бодит орлого нэмэгдсэнээр үйлчилгээний салбарын дийлэнхийг бүрдүүлдэг бөөний болон жижиглэн худалдааны салбар 6.8 хувиар өсөв. Мөн мэдээлэл, холбооны салбар 17.4 хувиар, үйлчилгээний бусад салбаруудын гарц 7.1 хувиар тэлсэн байна.

Харин том малын зүй бус хорогдол 2024 оны эхний хагас жилд 8.1 сая толгойд хүрч, өмнөх оны мөн үеэс 4.2 сая толгой малаар нэмэгдсэнээр хөдөө аж ахуйн салбар өмнөх оны мөн үеэс 26.7 хувиар агшиж, нийт эдийн засгийн өсөлтийг 3.9 нэгж хувиар хязгаарлалаа.

Шигтгээ 1. Том малын зүй бус хорогдол

Том малын зүй бус хорогдол 2024 оны эхний хагас жилийн байдлаар 8.1 саяд хүрч, өмнөх оноос 4.2 саяар буюу 2.1 дахин нэмэгдсэн байна. Малын зүй бус хорогдол нийт малын 12.5 хувьд хүрсэн нь сүүлийн 15 жилийн турш дах дээд хэмжээнд хүрлээ. Мал аж ахуйн салбар нь хөдөө аж ахуйн салбарын 93 орчим хувийг бүрдүүлдэг бөгөөд малын хорогдол эрс нэмэгдсэнээр тус салбар 26.7 хувиар агшиж, нийт эдийн засгийн өсөлтийг хязгаарлалаа.

График 2. Малын хорогдол, төрлөөр, мян.толгой





График 3. Малын хорогдол, аймгаар, мян.толгой



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Том малын зүй бус хорогдлыг төрлөөр нь авч үзвэл, хонь 4.4 сая, ямаа 2.6 сая, үхэр 695.9 мянга, адуу 453.3 мянга, тэмээ 5.7 мянган толгой хорогдсон байна. Нийт хорогдсон малын 53.8 хувийг хонь, 31.9 хувийг ямаа эзэлж байна.

Сүхбаатар аймагт 1.8 (22.5 хувь) сая, Хэнтий аймагт 1.0 (12.4 хувь) сая, Архангай аймагт 952.3 (11.8 хувь) мянга, Төв аймагт 715.4 (8.8 хувь) мянга, Дорноговь аймагт 614.0 (7.6 хувь), Булган аймагт 570 (7.1 хувь) мянган мал хорогдсон нь нийт хорогдлын 70 хувийг эзэлж байна.

1.1.2. Эцсийн ашиглалтын аргаар тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүн

Эцсийн ашиглалтын аргаар тооцсон нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүн 2024 оны эхний хагас жилд 38 их наяд төгрөгт хүрч 24.5 хувиар өссөн бол 2015 оны үнээр

тооцсон бодит дотоодын нийт бүтээгдэхүүн 14.1 их наяд төгрөгт хүрч 5.7 хувиар өслөө.

Хүснэгт 2. Эцсийн ашиглалтын аргаар тооцсон бодит ДНБ-ий өсөлт, бүрэлдэхүүнээр (хувь)

Үзүүлэлт	2021.И	2022.И	2023.И	2024.И
ДНБ	6.2	-0.2	6.3	5.7
Эцсийн хэрэглээ	-8.7	6.1	7.7	21.5
Өрхийн хэрэглээ	-7.1	5.0	4.7	12.1
Төрийн байгууллагын хэрэглээ	-1.5	1.1	3.1	9.3
Хөрөнгийн нийт хуримтлал	12.5	14.3	-14.9	6.2
Үндсэн хөрөнгийн хуримтлал	3.2	3.7	2.2	0.2
Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт	9.3	10.5	-17.0	6.0
Бараа, үйлчилгээний цэвэр экспорт	2.3	-20.5	13.4	-21.9
Бараа, үйлчилгээний экспорт	6.1	-6.6	37.1	-1.5
Бараа, үйлчилгээний импорт (-)	3.7	13.9	23.7	20.5

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Энэхүү өсөлтөд эцсийн хэрэглээ 21.5 хувийн, хөрөнгийн нийт хуримтлал 6.2 хувийн эерэг оролцоотой байсан бол цэвэр экспорт -21.9 хувийн сөрөг оролцоотой байжээ.

Засгийн газар тэтгэвэр, тэтгэмж болон төрийн албан хаагчдын цалинг үе шаттай нэмэгдүүлснээр төрийн хэрэглээ 47 хувиар өссөн, эдийн засгийн идэвхжил, өрхийн бодит орлого нэмэгдэж хувийн хэрэглээ 17 хувиар өссөн нь эдийн засгийн өсөлтөд голлох нөлөө үзүүллээ.

Гадаад эдийн засгаас хүлээн авсан цэвэр орлого 2024 оны эхний хагас жилд 3.8 их наяд төгрөгийн алдагдалтай, хоёрдогч орлого буюу цэвэр шилжүүлэг 857.7 тэрбум төгрөгийн ашигтай гарч, үндэсний нийт орлого оны үнээр 33.6 их наяд төгрөг болж 22.6 хувиар өслөө.

Шигтгээ 2. Өрхийн бодит орлого

Өрхийн нэрлэсэн орлого 2024 оны II улиралд 2.5 сая төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 486 мянган төгрөгөөр буюу 24 хувиар өссөн бол үнийн нөлөөллийг арилган, 2020 оны үнээр тооцсон бодит орлого 1.7 сая төгрөгт хүрч 255 мянган төгрөгөөр буюу 17.3 хувиар өслөө.

График 4. Өрхийн сарын дундаж орлого, мянган төгрөг





График 5. Өрхийн бодит орлого бүрэлдэхүүнээр, мянган төгрөг




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Энэхүү өсөлтөд үнийн нөлөөллийг арилгасан бодит цалингийн орлого 31 хувиар, тэтгэвэр, тэтгэмжийн орлого 9 хувиар өссөн нь голлох нөлөө үзүүлсэн байна. Засгийн газар 2023, 2024 онд төрийн албан хаагчдын цалин, тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлэх шат дараалсан арга хэмжээ авч хэрэгжүүлсэн нь бодит орлогын өсөлтөд эерэг нөлөө үзүүлээ.

1.2. ГАДААД ХУДАЛДАА

Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2024 оны эхний 6 сарын байдлаар 13.3 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 12.2 хувиар өссөн бол худалдааны тэнцэл 2.5 тэрбум ам.долларын ашигтай гарлаа. Экспорт 7.9 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 4.4 хувиар өсөв. Уурхайн хяналт шалгалтын улмаас БНХАУ-ын коксжих нүүрсний дотоод үйлдвэрлэл буурч, импорт нэмэгдсэн нь манай улсын коксжих нүүрсний экспортыг тэтгэж, Монгол Улс 2024 оны эхний 6 сард 40.6 сая тонн нүүрс экспортолж, нүүрсний

График 6. Гадаад худалдааны нийт бараа эргэлт (тэрбум ам.доллар)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

экспорт өнгөрсөн оны мөн үеэс 38 хувиар нэмэгдлээ. Оюутолгойн гүний уурхайн олборлолт эхэлсэн, төмөр замын тээвэр зохион байгуулалтыг сайжруулсан зэргээс шалтгаалан зэсийн баяжмалын экспорт 2024 оны эхний 6 сард 785 мянган тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 3 хувиар, төмрийн хүдрийн экспорт 3,596 мянган тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 34 хувиар тус тус нэмэгдлээ. Нийт нутгийн ихэнх хэсэгт өвөлжилт, хаваржилт хүндэрсэнтэй холбоотойгоор 2024 оны эхний 6 сард өмнөх оны мөн үетэй харьцуулахад махны экспорт 57 хувиар, ноосны экспорт 45 хувиар, арьс ширний экспорт 31 хувиар тус тус буурлаа.

Шигтгээ 3. Нүүрсний олборлолт, экспорт

Нүүрсний олборлолт 2024 оны эхний хагаст 47.8 сая.тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 36 хувиар нэмэгдлээ. Нүүрсний экспорт эхний хагас жилд 40.6 сая.тоннд хүрсэн бөгөөд нийт олборлосон нүүрсний 85 хувийг экспортолсон байна. Нийт экспортолсон нүүрсний 39.5 сая.тонныг чулуун нүүрс бүрдүүлж байна.

График 7. Нийт нүүрсний олборлолт ба экспорт, сая.тонн



Хүснэгт 3. Чулуун нүүрсний экспорт, боомтоор, сая.тонн

	2023.6	2024.6	Өөрчлөлт
Гашуунсүхайд	15.8	20.3	29%
Шивээхүрэн	6.8	11.8	73%
Ханги	2.4	4.0	70%
Булган	1.4	1.8	29%
Замын-Үүд	2.0	1.5	-23%
Нийт	28.4	39.5	39%

Эх сурвалж: Гаалийн Ерөнхий газар

Нийт экспортолсон чулуун нүүрсний 51 хувийг (20.3 сая) Гашуунсүхайд боомтоор, 30 хувийг (11.8 сая) Шивээхүрэн боомтоор, 10 хувийг (4.0 сая) Ханги боомтоор, 5 хувийг (1.8 сая) Булган боомтоор, 4 хувийг (1.5 сая) Замын-Үүд боомтоор тус тус гаргасан байна. Шивээхүрэн, Ханги боомтын чулуун нүүрсний экспорт өмнөх оноос 70-73 хувиар нэмэгджээ.


Импорт 2024 оны эхний 6 сард 5.4 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оноос 25.9 хувь буюу 1.1 тэрбум ам.доллараар нэмэгдлээ. Зээл олголт, гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдсэнээр тоног төхөөрөмжийн импорт өмнөх оны мөн үеэс 42.3 хувиар өссөн нь импортын өсөлтөд голлон нөлөөлсөн байна. Мөн өрхийн бодит орлого болон иргэдийн хэрэглээний зээл өссөнөөр худалдан авах чадвар сайжирч,

хэрэглээний бараа, бүтээгдэхүүний импорт 22.3 хувиар өссөн ба тэр дундаа автомашины импортын өсөлт өндөр байна.

1.3. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ

Төлбөрийн тэнцэл 2024 оны эхний 6 сард 57 сая ам.долларын алдагдалтай гарлаа. Барааны импорт өмнөх оны мөн үеэс 1.1 тэрбум ам.доллороор өссөнөөр урсгал данс 309 сая ам.долларын алдагдалтай гарсан бол гадаад бондын төлбөр болон худалдааны зээлтэй холбоотой гадаад валютын гарах урсгал буурснаар санхүүгийн данс 721 сая ам.долларын ашигтай гарлаа. Засгийн газар 2024 оны 3 дугаар сард Хуралдай бондын үлдэгдэл өр төлбөрийг бүрэн төлж барагдууллаа. Мөн эхний улиралд “МИК ОССК” 225 сая ам.долларын, Монгол Улсын Хөгжлийн Банк 200 сая ам.долларын бондыг зах зээлд амжилттай арилжсан бол II улиралд Монголбанк Хятадын Ардын банкттай байгуулсан своп хэлцлийн гэрээний дагуу 4.5 тэрбум юанийн эргэн төлөлтийг хийгээд байна. Улмаар гадаад валютын албан нөөц 2024 оны 6 дугаар сарын эцсийн байдлаар 4.8 тэрбум ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 1.0 тэрбум ам.доллороор нэмэгдлээ.

График 8. Төлбөрийн тэнцэл (сая ам.доллар)



Эх сурвалж: Монгол банк


1.4. ИНФЛЯЦ

Улсын хэмжээнд 2024 оны 6 дугаар сарын инфляц 5.1 хувь болж өмнөх оны мөн үеэс 5.6 нэгж хувиар буурч Монголбанкны инфляцын зорилтот түвшин болох 6 ± 2 хувийн түвшинд байна. Инфляцын бууралтын 3.7 нэгж хувийг хүнсний бараа, согтууруулах бус ундаа, 0.7 нэгж хувийг хувцас, бөс бараа, гутал, 0.2 нэгж хувийг орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш, 0.3 нэгж хувийг гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа, 0.3 нэгж хувийг тээвэр, 0.5 нэгж хувийг бусад бараа, үйлчилгээ тус тус бүрдүүлсэн байна.

Импортын инфляцын нийт инфляцад үзүүлэх нөлөө 2023 оноос эхлэн алгуур буурч тогтворжоод байна. Тухайлбал, 2024 оны 6 дугаар сард импортын барааны үнийн өсөлт нийт инфляцын 1.8 нэгж хувь буюу 35.3 хувийг эзэллээ. Импортын инфляц буурахад төгрөгийн ханш тогтворжсон, гадаад үнэ буурсан болон цар тахлаас үүдэлтэй тээвэр логистикийн саатал арилсан зэрэг хүчин зүйлс голлон нөлөөлөв.

Дотоодын бараа, үйлчилгээний үнэ 2024 оны 6 дугаар сард нийт инфляцын 3.3 нэгж хувийг бүрдүүллээ. Дотоодын хүнсний үнийн өсөлт саарч, жилийн 4.7 хувиар өссөн нь нийт инфляцын 1.4 нэгж хувийг бүрдүүлж байна. Мөн үйлчилгээний бүлгийн үнийн өсөлт саарч, жилийн 6.8 хувиар өссөн нь нийт инфляцын 1.5 нэгж хувийг бүрдүүлэв. Үйлчилгээний бүлгийн инфляцад боловсролын үйлчилгээний үнэ 2023 оны 8 дугаар сард 16.8 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

График 9. Жилийн инфляц ба зорилтот түвшин (хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ХОЁРДУГААР БҮЛЭГ.

2024 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛ

БҮЛЭГ ХОЁР. 2024 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Шигтгээ 4. 2024 оны төсвийн бодлогын тойм

Нэг. Монгол Улс 2024 оны төсвийн бодлогоор “Шинэ сэргэлтийн бодлого”-ын тулгуур бүрэлдэхүүн болох “Хот, хөдөөгийн сэргэлт”-ийн зорилтод тусгасан хот, хөдөөгийн тэнцвэртэй хөгжлийг хангах, орон нутгийн иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Хоёр. Экспортыг нэмэгдүүлэх чиглэлд хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, уул уурхайн бүтээгдэхүүний биржийн ил тод арилжааг эрчимжүүлэх, иргэдийн орлогыг хамгаалах чиглэлд цалин, тэтгэвэр тэтгэмжийг үнийн өсөлттэй уялдуулан нэмэгдүүлэх, хөгжилд суурилсан хөрөнгө оруулалтыг эрчимжүүлэхэд чиглэсэн төсвийн бодлогыг хэрэгжүүлнэ.

Гурав. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан иргэд эх орондоо оношлогдон, эмчлүүлэх боломжийг нэмэгдүүлж, орчин үеийн үндэсний оношилгоо, эмчилгээний төвүүдийг байгуулна.

Дөрөв. Уул уурхайн орлогын тодорхой хувиас бүрдэж, тухайн орон нутгийн иргэдийн санал санаачилга дээр тулгуурлан, иргэдийн ая тухтай амьдрах орчныг сайжруулахад чиглэсэн Орон нутгийн хөгжлийн сангаас уул уурхайн олборлолт хийгдэж буй аймгуудад нэмэлтээр хуваарилагдаж, үүнээс сумдад олгох санхүүжилтийг 60 хувьд хүртэл нэмэгдүүлнэ. Ингэснээр тогтвортой, хариуцлагатай уул уурхайг дэмжиж, эдийн засгийн эргэлтэд оруулан, байгалийн баялгийн үр өгөөжийг орон нутгийн хөгжилд чиглүүлэх боломж бүрдэнэ.

2.1. ТӨСВИЙН ОРЛОГО

2.1.1. Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэл

Монгол Улсын Засгийн газар экспортыг эрчимжүүлэх, эдийн засгийг идэвхжүүлэх, иргэдийн орлогыг хамгаалах хүрээнд шат дараалсан бодлогын арга хэмжээг хэрэгжүүлж байна. Мөн төрийн өмчит компанийн засаглал, ил тод байдлыг сайжруулах, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх чиглэлээр цаг үеийн шинжтэй шийдвэрийг шуурхай гаргаж хэрэгжүүлсний үр дүнд 2020 онд 4.6 хувиар агшаад байсан эдийн засаг 2023 онд 7.0 хувийн өсөлттэй гарлаа. Мөн 16 сая тонн болж уналтад ороод байсан нүүрсний экспорт 2023 онд 69.6 сая тоннд хүрч түүхэн дээд амжилт тогтоосон. Эдгээр бодлогын нөлөөгөөр төсвийн орлогын төлөвлөгөө сүүлийн 4 жил тасралтгүй давж биеллээ.

2024 оны эхний хагас жилийн байдлаар Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого 14,947.1 тэрбум төгрөгт хүрч, жилийн батлагдсан дүнтэй харьцуулахад 54 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4. 2024 оны эхний 6 сарын нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэл (тэрбум төгрөг)

ҮЗҮҮЛЭЛТ	2023.06 ГҮЙЦ	2024.06 ГҮЙЦ	ЗӨРҮҮ
Нийт орлого	11,059.3	14,947.2	3,887.8
Тогтворжуулалтын сан	477.9	220.7	-257.3
Тэнцвэржүүлсэн орлого	10,581.3	14,198.8	3,617.5
Татварын орлого	9,841.2	13,291.0	3,449.8
Татварын бус орлого	740.1	907.8	167.7

Эх сурвалж: Сангийн яам

Эхний хагас жилийн орлогын гүйцэтгэлийг өмнөх оны мөн үеийн орлогын гүйцэтгэлтэй харьцуулахад 3,887.9 тэрбум төгрөгөөр буюу 35.2 хувиар өсжээ. Үүнд, эдийн засаг идэвхжиж, гадаад худалдааны эргэлт сайжирч, нүүрсний экспорт 40.6 сая тоннд хүрч, улмаар уул уурхай болон тээвэр, үйлчилгээний салбарын орлого өсөж, үүнээс улбаалан аж ахуйн нэгжүүдийн борлуулалт сайжирсан нь голлон нөлөөлсөн байна.

2.1.2. Уул уурхайн салбарын орлогын гүйцэтгэл

Уул уурхайн салбараас 2024 оны эхний хагас жилд нийт 6,371.3 тэрбум төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн бөгөөд өмнөх оны үеэс 73 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Уул уурхайн салбарын орлого нэмэгдэхэд дараах хүчин зүйлс голлон нөлөөлсөн байна. Үүнд:

- Хилийн боомтоор нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлсэн;
- Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагааг идэвхжүүлж, экспортолж буй бүтээгдэхүүний үнэлгээг олон улсын жишигт нийцүүлсэн;
- Төрийн өмчит компанийн засаглал, ил тод байдлыг сайжруулсан, ашигт ажиллагааг нэмэгдүүлсэн;
- Оюу толгой компанийн гүний уурхай ашиглалтад орж, баяжмалын хэмжээ нэмэгдсэн зэрэг болно.

Хүснэгт 5. 2024 оны эхний 6 сарын уул уурхайн салбарын орлогын гүйцэтгэл, ашигт малтмалын төрлөөр (тэрбум төгрөг)

ҮЗҮҮЛЭЛТ	2023.06 ГҮЙЦ	2024.06 ГҮЙЦ	ЗӨРҮҮ
Уул уурхайн салбарын орлого	3,684.2	6,371.3	2,687.1
Зэсийн баяжмал	1,221.1	1,367.6	146.5
Нүүрс	2,110.6	4,519.1	2,408.5
Төмрийн хүдэр	46.8	87.9	41.1
Алт	114.3	179.8	65.5
Бусад	191.4	216.9	25.5

Эх сурвалж: Сангийн яам

Нүүрсний экспорт 2024 оны эхний хагас жилд нийт нүүрсний экспорт 40.6 сая тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 38 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Үүнээс, уул уурхайн бүтээгдэхүүний биржээр 14.6 сая тонныг борлуулсан нь нийт нүүрсний экспортын 36 хувийг эзэлж байна. Уул уурхайн бүтээгдэхүүний биржээр ашигт

малтмалын бүтээгдэхүүнийг ил тод, нээлттэй, олон улсын зах зээлийн үнээр борлуулснаар бүтээгдэхүүний үнэлгээг нэмэгдүүлсэн зэрэг эерэг нөлөөтэй байна. Улмаар нүүрсний орлого 2024 оны эхний 6 сарын байдлаар 4,519.1 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 2,408.5 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

2.2. ТӨСВИЙН ЗАРЛАГА

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн хэмжээ 12,911.3 тэрбум төгрөгт хүрч төлөвлөсөн дүнгээс 3,452.0 тэрбум төгрөгөөр бага буюу 78.9 хувийн гүйцэтгэлтэй байна. Нийт зарлагын 32.9 хувь буюу 4,244.8 тэрбум төгрөгийг бараа ажил үйлчилгээний зардал, 4.6 хувь буюу 595.1 тэрбум төгрөгийг гадаад зээлийн үйлчилгээний төлбөрт, 40 хувь буюу 5,169.6 тэрбум төгрөгийг засгийн газрын гадаад, дотоод урсгал шилжүүлэг, 2.8 хувь буюу 366.7 тэрбум төгрөгийг татаасны зориулалтад, 17.8 хувь буюу 2,296.0 тэрбум төгрөгийг хөрөнгийн зардал тус тус зарцуулсан байна.

Хүснэгт 6. 2024 оны эхний 6 сарын төсвийн зарлагын гүйцэтгэл (тэрбум төгрөг)

ҮЗҮҮЛЭЛТ	2023.06 ГҮЙЦ	2024.06 ГҮЙЦ	ЗӨРҮҮ
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9,033.8	12,911.3	3,877.5
НИЙТ ЗАРЛАГА	9,000.5	12,672.2	3,671.7
УРСГАЛ ЗАРДАЛ	7,556.6	10,376.2	2,819.6
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,044.6	4,244.8	2,200.2
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	951.2	2,585.0	1,633.8
Үндсэн цалин	581.2	1,587.8	1,006.6
Нэмэгдэл	280.8	793.8	513.0
Унаа хоолны хөнгөлөлт	46.6	88.5	41.8
Урамшуулал	23.6	79.8	56.2
Гэрээт ажлын хөлс	18.9	35.1	16.2
Байр ашиглалттай холбоотой зардал	195.3	254.7	59.4
Гэрэл, цахилгаан	36.8	49.3	12.5
Түлш, халаалт	126.1	163.7	37.6
Цэвэр, бохир ус	14.0	20.4	6.4
Байрны түрээс	18.4	21.3	2.9
Хангамж, бараа материалын зардал	85.0	130.9	45.9
Нормативт зардал	119.7	138.2	18.5
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	36.4	27.8	-8.6
Хоол, хүнс	73.4	85.2	11.8
Нормын хувцас, зөөлөн эдлэл	9.9	25.2	15.3
Эд хогшил, урсгал засварын зардал	47.1	79.1	32.0
Томилолт, зочны зардал	17.6	28.2	10.6
Гадаад албан томилолт	8.2	10.5	2.4
Дотоод албан томилолт	7.0	12.6	5.6
Зочин төлөөлөгч хүлээн авах	2.5	5.1	2.6
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	408.0	517.8	109.8
Бараа үйлчилгээний бусад зардал	220.7	510.9	290.1
ХҮҮ	513.8	595.1	81.3
Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	459.7	582.0	122.3
Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	54.1	13.1	-41.0
ТАТААС	266.5	366.7	100.2

Төрийн өмчит байгууллагад олгох татаас	76.8	91.0	14.2
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	189.7	275.6	86.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,731.8	5,169.6	437.9
Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,733.6	1,218.1	-515.5
Бусад урсгал шилжүүлэг	2,998.2	3,951.5	953.3
Нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмж	1,785.1	2,452.0	666.9
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	972.3	1,158.9	186.6
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3.1	6.6	3.4
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	123.6	125.5	1.9
Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт	0.0	0.0	0.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	62.1	56.1	-5.9
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх	46.4	142.9	96.5
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5.6	9.5	3.9
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,443.9	2,296.0	852.1
Барилга байгууламж	979.9	1,400.5	420.6
Их засвар	41.2	76.1	34.9
Тоног төхөөрөмж	188.2	248.6	60.5
Бусад хөрөнгө	233.3	561.3	328.0
Стратегийн нөөц хөрөнгө	1.3	9.5	8.2
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	33.3	239.1	205.8

Эх сурвалж: Сангийн яам

2.3. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 1299 төсөл, арга хэмжээний санхүүжилтэд 3,359.4 тэрбум төгрөг, эргэн төлөлт хийгдэх концессын 1 төсөл, арга хэмжээнд 25.0 тэрбум төгрөг, нийтдээ 1300 төсөл, арга хэмжээнд 3,384.4 тэрбум төгрөг батлагдсан.

Гүйцэтгэлийг төсвийн ерөнхийлөн захирагчийн багц дүнгээр 2024 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 7. Улсын төсвийн хөрөнгө оруулалт (тэрбум төгрөг)

ТЭЗ	ТӨСЛИЙН ТОО	ТӨСӨВТ ӨРТӨГ	САНХҮҮЖИХ ДҮН	НИЙТ ГҮЙЦЭТГЭЛ 2024.06	ХУВЬ 2024.06	ҮЛДЭГДЭЛ САНХҮҮЖИЛТ	ХБГ /90%/
МУИХД	2	22.09	22.09	5.03	22.8%	17.06	19.88
МУЕС	1	1.20	1.20	0	0.0%	1.20	1.08
МУШС	10	35.48	25.69	2.44	9.5%	23.25	23.12
МУШСБЭЗХС	2	55.30	44.00	1.40	3.2%	42.60	39.60
МУСЗГХЭГД	39	102.36	51.39	4.56	8.9%	46.83	46.25
ГХС	2	13.70	13.70	9.21	67.2%	4.49	12.33
САС	8	664.51	224.78	17.02	7.6%	207.75	202.30
ХЗДХС	39	195.08	127.19	38.34	30.1%	88.85	114.47
БОАЖС	24	57.27	36.94	1.24	3.3%	35.70	33.24
БХС	8	29.20	20.02	4.19	20.9%	15.83	18.01
БХБС	140	1,145.33	405.29	60.24	14.9%	345.05	364.76
БШУС	442	2,380.81	744.87	130.55	17.5%	614.32	670.38
ЗТХС	120	2,757.07	612.01	55.75	9.1%	556.26	550.81
СОС	86	566.97	154.88	23.40	15.1%	131.48	139.39
ХНХС	43	134.60	48.76	9.31	19.1%	39.45	43.88
ХХААХҮС	79	246.08	123.59	10.31	8.3%	113.28	111.23
ЦХХХС	11	31.99	16.42	0.3396	2.1%	16.08	14.78
ЭХС	55	630.87	224.29	49.32	22.0%	174.97	201.86
ЭМС	126	690.34	281.08	54.52	19.4%	226.55	252.97

МУСНУХАЗТБҮХ	2	362.95	56.23	27.93	49.7%	28.30	50.61
МУСОНБТСҮХД	44	270.72	72.35	13.10	18.1%	59.25	65.12
МУСБСҮХД	2	5.46	5.46	1.14	20.8%	4.33	4.92
УДШЕШ	2	11.53	11.53	0	0.0%	11.53	10.38
УЕП	3	90.78	19.83	0	0.0%	19.83	17.84
ШЕЗ	6	45.99	11.35	4.94	43.5%	6.41	10.21
МУЕА	1	0.88	0.88	0	0.0%	0.88	0.79
АТГД	1	2.66	2.66	0.15	5.6%	2.51	2.39
СЗХД	1	0.89	0.89	0	0.0%	0.89	0.80
УТ	1299	10,552.12	3,359.35	524.43	15.6%	2,834.92	3,023.42
КО	1	287.40	25.00	0	0.0%	25.00	25.00
НИЙТ	1300	10,839.52	3,384.35	524.43	15.5%	2,859.92	3,048.4

Эх сурвалж: Сангийн яам

Эхний хагас жилийн байдлаарх санхүүжилтийн хувь бага байгаа нь шилжин хэрэгжиж буй төслүүдийн 2023 оны жилийн эцэст үлдэгдэл санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулах, төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн явц байдалтай уялдуулан хөрөнгийн зохицуулалт хийж, санхүүжүүлэх буюу гүйцэтгэлийн явц удааширч, батлагдсан санхүүжилтээ бүрэн авах боломжгүй нөхцөл байдал үүссэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг гүйцэтгэлийн явц сайн үргэлжилж буй төсөл, арга хэмжээнд нэмж санхүүжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлснээр өмнөх оноос давсан гүйцэтгэлийг санхүүжүүлэх шаардлага үүсээгүйтэй буюу зарим төслүүд хугацаанаас өмнө ашиглалтад орох боломжийг бүрдүүлсэнтэй холбоотой байна. Харин шинэ төслүүдийн хувьд төсөл, арга хэмжээний бэлтгэл хангах, худалдан авах ажиллагааг эхлүүлэх, гүйцэтгэгч сонгон шалгаруулахтай холбоотойгоор эхний хагас жилд гүйцэтгэл бага байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд барилга, байгууламжийн 1,020 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгагдсан.

Тухайлбал:

- Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын байгууллагын барилга байгууламж, хүчин чадлыг нэмэгдүүлэх, орчин нөхцөлийг сайжруулах чиглэлээр 19.7 мянган ор бүхий 149 цэцэрлэг, 60,000 орчим суудал бүхий 156 сургууль, 1,700 ор бүхий 19 дотуур байр;
- Эрүүл мэнд, эмнэлгийн тусламж үйлчилгээний барилга байгууламж, хүртээмжийг нэмэгдүүлэх, орчин нөхцөлийг сайжруулах чиглэлээр 3000 орчим ор бүхий 43 эмнэлэг, орон нутгийн иргэдийг соён гэгээрүүлэх, соёлын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зориулалт бүхий барилга байгууламжийн чиглэлээр 63 соёлын төв;
- Бүс, орон нутгийн хөгжил, аялал жуулчлалыг дэмжих, сум, сууриныг холбох болон доторх авто замын хүчин чадлыг сайжруулах дэд бүтцийг нэмэгдүүлэх чиглэлээр 1,883.2 километр бүхий 106 зам, гүүрний барилга;
- Эрчим хүчний эх үүсвэр, үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, инженерийн шугам сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлэх, шинэ эх үүсвэр бий болгох чиглэлээр 55 төсөл, арга хэмжээ батлагдсан байна.

Харин их засвар, тоног төхөөрөмж, техник эдийн засгийн үндэслэл боловсруулахад 280 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлагдсан байна.

Эдгээр төслүүдийг хэрэгжүүлснээр 40.9 мянган ажлын байрыг хадгалж, 1500 гаруй аж ахуй нэгжийг үйл ажиллагаагаа хэвийн үргэлжлүүлэх боломжоор хангах бөгөөд 2024 онд нийт төслүүдийн 55 хувь нь бүрэн хэрэгжиж, 45 хувь нь дараа онууд руу шилжихээр байна.

2.4. ЗАСГИЙН ГАЗРЫН ГАДААД ЗЭЭЛ, ТУСЛАМЖ

Монгол Улсын 2024 оны төсөвт нийт 2,767.0 тэрбум төгрөгийн гадаад зээл, тусламжийн төслийн санхүүжилтийг авч ашиглахаар төлөвлөгдсөнөөс 2024 оны 7 дугаар сарын эцсийн байдлаар Засгийн газрын гадаад төслийн зээл 1,154.5 тэрбум төгрөг буюу 52.3 хувийн гүйцэтгэлтэй, тусламж 169.4 тэрбум төгрөг буюу 30.0 хувийн гүйцэтгэл, нийт гүйцэтгэл 1,323.9 тэрбум төгрөг буюу 47.8 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 8. Засгийн газрын гадаад зээл, тусламжийн гүйцэтгэл (тэрбум төгрөг)

Ангилал	Төслийн тоо	2024 оны батлагдсан төсөв	Гүйцэтгэл /2024.07.23/	Хувь	Үлдэгдэл
Гадаад зээл	101	2,209.0	1,154.5	52.3%	1,054.5
Гадаад тусламж	29	558.0	169.4	30%	388.6
НИЙТ	130	2,767.0	1,323.9	47.8%	1,443.1

Эх сурвалж: Сангийн яам

Гадаад зээл, тусламжийн төслийн санхүүжилтийг нийт 19 хөгжлийн түнш орон, олон улсын байгууллагаас хүлээн авч, төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна. Үүнд:

Хүснэгт 9. Гадаад зээл, тусламжийн төсөл хөтөлбөр, хөгжлийн түншээр (тэрбум төгрөг)

Д/д	Хөгжлийн түнш	Төслийн тоо	2024 оны батлагдсан төсөв	2024 оны санхүүжилтэд эзлэх хувь	Гүйцэтгэл /2024.07.23/
1	Азийн хөгжлийн банк	57	646.5	23.4%	383.5
2	АНУ	1	328.8	11.9%	128.6
3	БНХАУ	14	580.1	21.0%	135.0
4	БНСУ	7	424.5	15.3%	229.5
5	БНЭУ	2	179.7	6.5%	126.4
6	Дэлхийн банк	16	133.9	4.8%	68.9
7	ЕСБХБ	12	227.2	8.2%	83.1
8	Австри	4	67.1	2.4%	66.9
9	БНФУ	2	67.5	2.4%	59.7
10	ХБНГУ	3	24.1	0.9%	7.8
11	Япон	1	4.9	0.2%	3.7
12	ЕХОБ	2	23.2	0.8%	11.3
13	АДБХОБ	1	36.6	1.3%	9.6
14	Боловсролын Дэлхийн түншлэл	1	8.5	0.3%	1.9

15	БНПУ	2	6.8	0.2%	-
16	Люксембург	1	2.7	0.1%	0.5
17	Кувейт	2	4.8	0.2%	0.6
18	ХААХОУС	1	0.1	0.0%	0.01
19	Беларусь	1	0.001	0.0%	-
	НИЙТ	130	2,767.0	100%	1,323.9

Эх сурвалж: Сангийн яам

БНЭУ-ын зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл”-ийн ЕРС-01 багц ажил буюу Үйлдвэрийн технологийн бус барилга байгууламжийн барилга угсралтын ажил 99 хувийн гүйцэтгэлтэй, ЕРС-02 багц ажил буюу Анхдагч процессын болон дагалдах байгууламжуудын барилга угсралтын ажил 13 хувь, ЕРС-03 багц ажлын буюу Лицензтэй технологийн байгууламжуудын барилга угсралтын ажил 12 хувийн гүйцэтгэлтэй байна. Мөн АНУ-ын Мянганы сорилтын сангийн тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй “Улаанбаатар хотын нийт ус хангамжийг нэмэгдүүлэх төсөл”-ийн хүрээнд Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэр байгуулах барилга угсралтын ажил 36 хувьтай, Ус гүн цэвэршүүлэх үйлдвэрийн барилга угсралтын ажил 67 хувийн гүйцэтгэлтэй байна. БНХАУ-ын зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй “Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл” нийт ажлын гүйцэтгэл 85 хувьтай 2025 онд бүрэн дуусгахаар төлөвлөн ажиллаж байна.

2.5. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСӨВ

Нийгмийн даатгалын сан 2024 оны эхний хагас жилд 2,070.2 тэрбум төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн орлого төвлөрүүлэхээс 2,023.0 тэрбум төгрөг, улсын төсвөөс төр хариуцах иргэдийн тэтгэвэр болон шимтгэлийн хөнгөлөлтийн татаас 806.7 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 806.7 тэрбум төгрөгийн татаас авсан байна. Нийгмийн даатгалын санд нийт 2,876.9 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 2,829.7 тэрбум төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөний гүйцэтгэл 98.3 хувьтай байна.

Хүснэгт 10. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага (тэрбум төгрөг)

А. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО

ҮЗҮҮЛЭЛТ	2023.06 ГҮЙЦ	2024.06 ГҮЙЦ	ЗӨРҮҮ
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	1,899.9	2,829.7	929.8
ТАТВАРЫН ОРЛОГО	1,591.0	2,023.0	432.0
Нийгмийн даатгалын орлого	1,591.0	2,023.0	432.0
Тэтгэврийн даатгалын шимтгэл	1,319.7	1,665.8	346.1
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	135.6	178.2	42.6
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	109.7	116.3	6.6
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	26.0	62.8	36.7
ЭМД-ын хураамжийн шимтгэл	0.0	0.0	0.0
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	308.9	806.7	497.9
Тусламжийн орлого	308.9	806.7	497.9
Тэтгэврийн санд олгох татаас	308.9	806.7	497.9

Б. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРДАЛ

ҮЗҮҮЛЭЛТ	2023.06 ГҮЙЦ	2024.06 ГҮЙЦ	ЗӨРҮҮ
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,801.1	2,433.9	632.8
УРСГАЛ ЗАРДАЛ	1,801.6	2,434.7	633.1
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	16.1	0.1	-16.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,785.5	2,434.6	649.1
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	98.8	395.8	297.1

Эх сурвалж: Сангийн яам

Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого өмнөх оны мөн үеэс өссөн нь:

- Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2023 оны “Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 12 дугаар тогтоолоор хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс сарын 660.0 мян.төг болгон нэмэгдүүлсэн;
- Засгийн газрын 2023 оны “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай” 240, “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоолуудаар төрийн албан хаагчдын үндсэн цалингийн хэмжээг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс нэмэгдүүлсэн;
- Засгийн газрын 2024 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 10.0 хувиар нэмэгдүүлсэн;
- Үндэсний статистикийн хорооны зарласнаар аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын дундаж цалин 2024 оны 1 дүгээр улирлын байдлаар 2,283.7 мян.төг болж нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 27.4 хувиар нэмэгдсэн;
- Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/-аар малчин, туслах малчин, эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч ажил хөдөлмөр эрхлээгүй эх, эсхүл эцгийн төлөх шимтгэлийн 50 хувийг улсын төсвөөс сар бүр хариуцан төлөхөөр хуульчилсан нь тус тус шалтгаалсан байна.

Нийгмийн даатгалын сан эхний хагас жилийн байдлаар нийт орлого ба тусламжийн дүн 2,829.7 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 2,433.9 тэрбум төгрөгт хүрч 395.8 тэрбум төгрөгийн ашигтай байна.

2.6. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР

Өрийн удирдлагын тухай хуулийн дагуу Сангийн яам нь “Засгийн газрын өр”-ийн үлдэгдлийг улирал тутам тооцон бэлтгэж, олон нийтэд мэдээлж байна.

Засгийн газрын өрийн үлдэгдэл 2023 оны жилийн эцсийн байдлаар, нэрлэсэн дүнгээр 30.8 их наяд төгрөг, өнөөгийн үнэ цэнээр ДНБ-ий 38.6 хувьтай, 2024 оны эхний хагас жилийн байдлаар 30.2 их наяд төгрөгтэй тэнцэж өнөөгийн үнэ цэнээр ДНБ-ий 33.2 хувьтай тус тус тэнцэж байгаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан Засгийн газрын өрийн тусгай шаардлагыг хангаж байна.

Хүснэгт 11. Засгийн газрын өрийн бүтэц (тэрбум төгрөг)

ӨРИЙН ХЭРЭГСЭЛ	2023.II	2023.IV	2024.II
I. Засгийн газрын дотоод өр	651.6	234.1	141.6
1.1 Үнэт цаас	651.6	234.1	141.6
II. Засгийн газрын гадаад өр	29,366.8	30,274.6	29,346.5
2.1 Үнэт цаас	9,070.6	9,141.9	8,716.3
2.2 Зээл	20,296.2	20,902.9	20,630.2
III. Засгийн газрын бусад өр	1,086.9	264.9	759.0
3.1 Засгийн газрын өрийн баталгаа	744.1	29.5	254.5
3.2 "Барих-шилжүүлэх" төрлийн концесс	338.3	230.9	0.0
3.3 Орон нутгийн зээллэг	4.5	4.5	504.5
ЗАСГИЙН ГАЗРЫН НИЙТ ӨР (I+II+III)	31,105.4	30,773.5	30,247.1
Хуулиар тогтоосон өрийн хязгаар	65.0%	65.0%	60.0%
Засгийн газрын өр (ӨҮЦ) / ДНБ	39.3%	38.6%	33.2%


Эх сурвалж: Сангийн яам

Засгийн газрын зүгээс олон улсын хөрөнгө оруулагчидтай тогтмол мэдээлэл солилцож олон улсын санхүүгийн зах зээлийн нөхцөл байдлыг сайтар судалсны үндсэн дээр 2024 оны төлөгдөх нөхцөлтэй "Хуралдай" бондын 600.0 сая ам.долларын төлбөрөөс 2023 онд хийсэн "Сенчири-2" болон "Сенчири-3" өрийн зохицуулалтуудын хүрээнд нийт 547.1 сая ам.долларыг шийдвэрлэсэн. Ингэснээр 2024 оны 03 дугаар сарын 09-ний өдөр үлдэгдэл 52.9 сая ам.долларын төлбөрийг төрийн сангийн мөнгөн хөрөнгөөс гүйцэтгэж "Хуралдай" бондын төлбөрийг бүрэн шийдвэрлэсэн болно.

2.7. ЗАСГИЙН ГАЗРЫН ДОТООД ҮНЭТ ЦААС

Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжааг 2017 оноос эхлэн зогсоосноос шалтгаалж 2016 онд 5.5 их наяд төгрөгт хүрээд байсан дотоод үнэт цаасны үлдэгдэл 2024 оны эхний хагас жилийн байдлаар 141.6 тэрбум төгрөгтэй тэнцэж байгаа бөгөөд үүнээс 45.0 тэрбум төгрөг төсвийн алдагдал санхүүжүүлэх, 96.6 тэрбум төгрөг нь “Сайн хувьцаа” хөтөлбөрийг санхүүжүүлэх зориулалтаар арилжаалсан үнэт цаас байна.

График 10. Засгийн газрын дотоод үнэт цаас (их наяд төгрөг)



2.8. ЗАСГИЙН ГАЗРЫН ГАДААД ЗЭЭЛ

Засгийн газрын гадаад зээлийн үлдэгдэл 2024 оны эхний хагас жилийн байдлаар 20,630.2 тэрбум төгрөгтэй тэнцэж байна. Тайлант хугацаанд нийт ашиглалтын хэмжээ 1,154.5 тэрбум төгрөгтэй, үндсэн төлбөрийн хэмжээ 604.4 тэрбум төгрөгтэй, хүүгийн төлбөр 284.6 тэрбум төгрөгтэй тус тус тэнцэж байна.

2.9. ЗАСГИЙН ГАЗРЫН ГАДААД ҮНЭТ ЦААС

Засгийн газрын гадаад үнэт цаасны үлдэгдэл 2024 оны эхний хагас жилийн байдлаар 2,578.0 сая ам.доллар буюу 8,716.3 тэрбум төгрөгтэй тэнцэж байна.

Хүснэгт 12. Засгийн газрын дотоод үнэт цаас (их наяд төгрөг)

№	Гадаад үнэт цаас	Хүү	Хугацаа	Үлдэгдэл тб ₮
1	Номад	5.125%	5.5 жил	1,954.2
2	Сенчири-2027	3.500%	6 жил	1,690.5
3	Сенчири-2028	8.650%	5 жил	2,197.7
4	Сенчири-2029	7.785%	5.5 жил	1,183.4
5	Сенчири-2031	4.450%	10 жил	1,690.5
НИЙТ				8,716.3

Эх сурвалж: Сангийн яам

Засгийн газраас 2023 оны 12 дугаар сард хугацаа нь тулаад байсан “Хуралдай” бондын үлдэгдэл төлбөрийг дахин санхүүжилт хийх өрийн зохицуулалтын арга хэмжээг Сенчири-3 төслийн хүрээнд 2023 оны 12 дүгээр сарын 05-ны өдөр амжилттай авч хэрэгжүүлж 2024 оны 3 дугаар сард эргэн төлөгдөх хуваарьтай “Хуралдай” бондын үлдэгдэл 392.5 сая ам.долларын бондын тодорхой хэсгийг буцаан худалдан авсан.

2.10. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН БАТАЛГАА

Засгийн газрын өрийн баталгааны үлдэгдэл 2024 оны хагас жилийн байдлаар 254.5 тэрбум төгрөгтэй тэнцэж байна.

Хүснэгт 13. Засгийн газрын өрийн баталгааны үлдэгдэл (тэрбум төгрөг)

№	Баталгаа гаргуулагч	Зээлийн дүн	Жил	Төлж дуусах он	Үлдэгдэл
1	Хөгжлийн банк	420 сая юань	10 жил	2031	226.0
2	Эрдэнэс Монгол	35 сая \$	15 жил	2031	28.5
НИЙТ					254.5

Эх сурвалж: Сангийн яам

“Эрдэнэс монгол” ХХК-д гаргасан Засгийн газрын баталгаа 2031 онд бүрэн төлөгдөх хуваарьтай байна. Азийн хөгжлийн банкнаас авч буй хөнгөлөлттэй техник туслалцааны зээл “Эрдэнэс Монгол” ХХК 2016 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр 35.0 сая ам.долларын ЛИБОР (6 сар) +0.6 хувийн хүүтэй, 15 жилийн хугацаатай зээлийг Азийн хөгжлийн банкнаас авсан бөгөөд Засгийн газрын 2016 оны 138 дугаар тогтоолоор Засгийн газрын баталгаа гаргасан. Зээлийн үлдэгдэл 2024 оны хагас жилийн байдлаар 28.6 тэрбум төгрөгтэй тэнцэж байгаа бөгөөд 2031 онд зээл төлөгдөж дуусна.

Улсын Их Хурлын 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 90 дүгээр тогтоол, Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 133 дугаар тогтоолын дагуу БНХАУ-ын Хөгжлийн банкны 420 сая юанийн зээлийн эх үүсвэрээр хэрэгжиж буй “Чойбалсан ДЦС-ыг 50 МВт-аар өргөтгөх төсөл”-ийн санхүүжилтэд зориулж Монгол Улсын Хөгжлийн банканд 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдөр Засгийн газрын өрийн баталгааг гаргасан бөгөөд тус дулааны цахилгаан станцын өргөтгөл нь 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдөр ашиглалтад орсон. Уг зээлийн эргэн төлөлт 2031 онд төлөгдөж дуусах хуваарьтай байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ.

МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСАГ, ТӨСВИЙН
ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ГҮЙЦЭТГЭЛ

БҮЛЭГ ГУРАВ. МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСАГ, ТӨСВИЙН ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ГҮЙЦЭТГЭЛ

Хүснэгт 14. Макро эдийн засаг болон улсын төсвийн үзүүлэлтүүд

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТӨСӨӨЛӨЛ	х/нэгж	2024 I-VI*	2024 ХБГ**
ДНБ, оны үнээр	их наяд төгрөг	37.4	79.2
Эдийн засгийн өсөлт	Хувь	5.6	5.6
Инфляц	Хувь	5.1	6.5
Гадаад худалдааны нийт эргэлт	тэрбум ам.доллар	13.3	28.0
Нийт экспорт	тэрбум ам.доллар	7.9	16.7
Нийт импорт	тэрбум ам.доллар	5.4	11.3
Гадаад худалдааны тэнцэл	тэрбум ам.доллар	2.5	5.4

УЛСЫН ТӨСВИЙН ТӨСӨӨЛӨЛ	х/нэгж	2024 I-VI*	2024 ХБГ**
Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого	их наяд төгрөг	14.2	28.9
Нэгдсэн төсвийн нийт зарлага	их наяд төгрөг	12.9	30.5
Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл	их наяд төгрөг	1.3	-1.6
ДНБ-д эзлэх хувь	Хувь	3.4	-2.0
ЗГ-н өрийн нийт хэмжээ	их наяд төгрөг	30.2	35.2
ДНБ-д эзлэх хувь	Хувь	38.3	44.4

*Гүйцэтгэл

**Хүлээгдэж буй гүйцэтгэл

3.1. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ

Эдийн засгийн өсөлт 2024 оны эцэст 5.6 орчим хувь байхаар төсөөлж байна. Оюутолгойн гүний уурхайн олборлолт үргэлжилснээр баяжмал дахь зэс болон алтны агууламж нэмэгдэхийн зэрэгцээ нүүрс, төмрийн хүдрийн олборлолт өссөнөөр уул уурхайн салбарын үйлдвэрлэл нэмэгдэхээр байна. Уул уурхайн салбарын дам нөлөөгөөр ачаа тээвэр өсөлттэй байх бол жуулчдыг татахад чиглэсэн арга хэмжээнүүдийн нөлөөгөөр 2024 оны сүүлийн хагас жилд аялал жуулчлал, үйлчилгээний салбар өсөх хүлээлттэй байна. 2022 онд батлагдсан Гаалийн албан татварыг хөнгөлөх тухай хуулийн дагуу хүнс, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах тоног төхөөрөмжийн импортын татварыг тэглэснээр 2023 онд тоног төхөөрөмжийн импорт нэмэгдсэн нөлөөгөөр 2024 онд боловсруулах салбарын гарц нэмэгдэхээр байна. Харин цаг агаарын таагүй нөхцөл байдлын улмаас том малын зүй бус хорогдол 2023 оны түвшнээс давж, хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл 2024 онд агшихаар байна. Цалин, тэтгэвэр, тэтгэмж нэмэгдсэнээр өрхийн хэрэглээ

өсөж, дотоод эрэлт сайжран, улмаар худалдаа, үйлчилгээний борлуулалт нэмэгдэн эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлэхээр байна.

3.2. ГАДААД ХУДАЛДАА

2024 оны гадаад худалдааны нийт эргэлт жилийн эцэст 27.9 тэрбум ам.долларт хүрч, худалдааны тэнцэл 5.4 тэрбум ам.долларын ашигтай гарахаар төсөөлж байна. Хилийн боомтуудын дэд бүтцийг сайжруулах, тээвэр зохион байгуулалтыг оновчтой хийх, уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагааг өргөтгөх зэрэг арга хэмжээнүүдийн үр дүнд нүүрсний экспорт 78.1 сая тоннд хүрч, нийт экспортын дүн 2024 оны эцэст 16.7 тэрбум ам.долларт хүрэх төлөвтэй байна. Харин өрхийн орлого, зээл олголт нэмэгдэж, эдийн засгийн өсөлт тогтвортой байснаар импорт 2024 оны эцэст 11.3 тэрбум ам.долларт хүрч өсөхөөр байна.

3.3. ИНФЛЯЦ

2024 оны сүүлийн хагаст улирлын нөлөөгөөр инфляц өсөх хандлагатай байгаа бөгөөд 2024 оны эцэст эрчим хүч, дулааны тарифыг нэмэгдүүлбэл 2024 оны жилийн дундаж инфляц 6.5 хувь болж бага зэрэг өсөх хандлагатай байна.

3.4. ТӨСВИЙН ОРЛОГЫН ХҮЛЭЭГДЭЖ БҮЙ ГҮЙЦЭТГЭЛ

Макро эдийн засгийн нөхцөл байдал, үндсэн үзүүлэлтүүд, энэ оны эхний хагас жилийн орлогын гүйцэтгэлд үндэслэн 2024 оны нэгдсэн төсвийн орлогыг шинэчлэн тооцлоо. Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн орлого 30,639.5 тэрбум төгрөгт хүрч, батлагдсан дүнгээс 2,917.4 тэрбум төгрөгөөр, тэнцвэржүүлсэн орлого 28,872.5 тэрбум төгрөгт хүрч, батлагдсан дүнгээс 3,017.3 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэхээр байна.

Засгийн газар төсвийн орлого бүрдүүлэх зорилгоор Боомтын сэргэлтийн хүрээнд авч хэрэгжүүлсэн бодлогын арга хэмжээнүүдийн үр дүнд хилийн боомтын нэвтрэх чадварыг сайжруулах, хилээр нэвтрүүлэх тээврийн хэрэгслийн тоог нэмэгдүүлснээр энэ онд нүүрсний экспортыг түүхэн дээд хэмжээнд буюу 78.1 сая тонн хүргэх зорилт тавин ажиллана. Энэ хүрээнд уул уурхайн салбараас төсөвт төвлөрүүлэх орлого 9 орчим их наяд төгрөгт хүрнэ гэж тооцлоо.

3.5. ТӨСВИЙН УРСГАЛ ЗАРЛАГЫН ХҮЛЭЭГДЭЖ БҮЙ ГҮЙЦЭТГЭЛ

Төсвийн нийт урсгал зардал 2024 онд 22.4 их наяд төгрөгт хүрэхээр байгаа бөгөөд үүний 59.4 хувийг төрөөс иргэдэд олгодог тэтгэвэр, тэтгэмж, халамж, хүүхдийн мөнгө, болон хуульд заасны дагуу тарифаар гүйцэтгэлд үндэслэн санхүүждэг эрүүл мэнд, боловсролын салбарын цалин хөлс, 16.9 хувийг төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагаатай холбоотой зардал, 14.4 хувийг бусад салбарын цалин хөлс нэмэгдэл, урамшууллын зардал, 5.3 хувийг гадаад, дотоод зээлийн хүүгийн төлбөр 4.0 хувийг төрөөс иргэн, аж ахуй нэгжид олгох хөнгөлөлт татаас тус тус эзэлж байна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ.

МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСАГТ УЧИРЧ
БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛҮҮД

БҮЛЭГ ДӨРӨВ. МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСАГТ УЧИРЧ БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛҮҮД

Хөрш орнуудыг хамарсан геополитикийн хүндрэлтэй асуудлууд, БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн тодорхойгүй байдал, дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнийн тодорхой бус байдал, эрчим хүчний дутагдал болон уур амьсгалын өөрчлөлт, байгаль, цаг уурын нөлөөлөл нь макро эдийн засгийн үзүүлэлтүүдэд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй байна.

4.1. ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТОДОРХОЙ БУС БАЙДАЛ

4.1.1 Түүхий эдийн эрэлт, үнэ буурах

Манай экспортын бүтээгдэхүүний гол худалдан авагч болох БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбарт уналт үргэлжилж, эдийн засгийн өсөлтийг сааруулах томоохон хүчин зүйл хэвээр байх эрсдэлтэй байна. Олон улсын байгууллагуудын хамгийн сүүлийн үеийн төсөөллөөр БНХАУ-ын эдийн засгийн өсөлт 2024 оны эцэст дунджаар 4.9 хувь байхаар байгаа нь зорилтот 5.0 хувиас бага зэрэг доогуур байна.¹

БНХАУ-ын Засгийн газраас үл хөдлөх салбарын уналтын эсрэг бодлогын арга хэмжээг удаа дараалан хэрэгжүүлж байгаа ч, дотоодын эрэлт хангалтгүй байгаагаас шалтгаалан орон сууцны үнэ, орон сууц борлуулалт, үл хөдлөх хөрөнгийн салбарын хөрөнгө оруулалт үргэлжлэн буурсаар байна. Үл хөдлөх хөрөнгө болон барилгын салбар нь БНХАУ-ын гангийн хэрэглээний 50 гаруй хувийг эзэлдэг бөгөөд салбарын бууралт нь гангийн болон бусад уул уурхайн бүтээгдэхүүний эрэлтэд сөргөөр нөлөөлж болзошгүй байна. Ингэснээр дэлхийн зах зээл дээрх зэс, нүүрс зэрэг голлох уул уурхайн бүтээгдэхүүний үнэ буурах эрсдэлтэй байна.

БНХАУ-ын Ерөнхийлөгч Ши Жинпинь өнгөрсөн 7 дугаар сард болсон Коммунист намын их хурлын үеэр **техник технологид суурилсан эдийн засгийг бий болгох эдийн засгийн хөгжлийн шинэ загварыг** танилцуулсан нь эдийн засгийн цаашдын тогтвортой өсөлтийг бий болгох хүлээлтийг үүсгэж байна. Тус хөгжлийн загварын хүрээнд 2029 он хүртэл 300 орчим арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс хотжилтыг өргөтгөх, техник технологийн үйлдвэр нэмж байгуулах зэрэг арга хэмжээнүүд туссан нь түүхий эдийн эрэлт тогтвортой байх боломжийг бий болгох магадлалтай.

Хүснэгт 15. БНХАУ-ын эдийн засгийн өсөлт ба голлох түүхий эдийн үнийн төсөөлөл

ҮЗҮҮЛЭЛТ	х/нэгж	2024.II	2024.IV ХБГ
БНХАУ-ын эдийн засгийн өсөлт	Хувь	4.7	4.9
Зэсийн үнэ	Ам.доллар/тонн	9,648.2	9,800.0
Австралийн коксжих нүүрс	Ам.доллар/тонн	269.6	249.9
Төмрийн хүдэр	Ам.доллар/тонн	107.5	103.0

Эх сурвалж: Bloomberg

¹ Эх сурвалж: Bloomberg Terminal

4.1.2 Дэлхийн эдийн засгийн сэргэлт удаашрах

ОХУ-Украины дайн, Ойрх Дорнодод өрнөж буй мөргөлдөөн, БНХАУ-Тайваний сэргөлдөөн зэрэг геополитикийн тогтворгүй нөхцөл байдал үргэлжилсэн хэвээр байгаа нь түүхий эдийн үнэ хэлбэлзэх, үнийн өсөлт үргэлжлэх эрсдэлийг дагуулж байна. Түүнчлэн АНУ зэрэг бусад өндөр хөгжилтэй улс орнуудад үйлчилгээний салбарын инфляц өндөр хэвээр байгаа нь бодлогын хүүг бууруулахгүй байх нөхцөлийг бүрдүүлж байна. Мөнгөний хатуу бодлого үргэлжилснээр олон улсын санхүүгийн зах зээл тогтворгүй байдалд орж дэлхийн эдийн засгийн идэвхжилийг хязгаарлаж болзошгүй юм. Дэлхийн эдийн засгийн идэвхжил саарах, түүхий эдийн үнийн тогтворгүй байдал үүсэх нь манай улсад орох хөрөнгийн урсгалыг бууруулах, уул уурхайн гол нэр төрлийн бүтээгдэхүүнүүдийн эрэлт болон үнэд сэргөөр нөлөөлөх эрсдэлтэй.

4.2. ДОТООДОД ҮҮСЭЖ БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛ

4.2.1. Малын өвчин, цаг агаар, ган зудын эрсдэл

Хөдөө аж ахуйн салбар нь байгаль, цаг уурын нөхцөл байдалтай шууд хамааралтай. Энэ онд өвөлжилт, хаваржилт хүндэрсний улмаас эхний хагас жилийн байдлаар том малын зүй бус хорогдол 8.1 сая буюу нийт малын 13 хувьд хүрээд байна. Улмаар хөдөө аж ахуйн салбарын нийлүүлэлтэд сэргөөр нөлөөлж, нийлүүлэлтийн гаралтай инфляцын дарамтыг нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлтөд сэргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна.

4.2.2. Зээлжих зэрэглэл буурах болон аливаа төрлийн хориг

Хөрш орнуудыг хамарсан геополитикийн хүндрэлтэй асуудлууд өрнөж буй энэ үед зээлжих зэрэглэл буурах, аливаа төрлийн хоригт өртөхгүй байх нь чухал байна. Иймд, манай улс олон улсад баримталж буй дүрэм журмуудыг сайтар мөрдөж, харилцан ойлголцож, зээлжих зэрэглэл тогтоох болон хориг арга хэмжээ авах эрх бүхий олон улсын байгууллагуудад хүргүүлэх холбогдох үнэлгээний тайлангуудыг сайтар бэлтгэх шаардлагатай. Зээлжих зэрэглэл буурч, аливаа хоригт орсон тохиолдолд гадаадын хөрөнгө оруулалт, гадаад зээлийн урсгал буурах, төлбөр тооцоо саатах зэрэг эрсдэлүүд үүсэж болзошгүй.

Холбоо барих

Вэб хуудас: www.mof.gov.mn

Хаяг: Монгол Улсын Сангийн яам, С.Данзангийн гудамж,
Засгийн газрын II байр Д корпус, Улаанбаатар 15160,
Монгол Улс
